



## БОДЛОГЫН ТОЙМ: ИЛ ТОД БАЙДАЛ, НЭЭЛТТЭЙ ЗАСАГ ВЭБ ХУУДАС, ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦОО 2004 оны 9 дүгээр сар

### Үндэслэл

Интернетийн үйлчилгээний дэлхийд тархаж буй хурд, гарч буй огцом үсрэлт нь харилцаа холбооны хувьд шинэ нөөц боломжуудыг байнга нээж, байгаа зүйлсийг өөр өнцгөөс харж, шинэ маягаар хийх хандлагыг тодорхойлж өгдөг. Аливаа засгийн газрын хувьд ч интернетийн хэрэглээ мөн адил байдаг. Засгийн газар бүр World Wide Web буюу интернет дээр өөрийн нэрийг гаргахыг эрмэлзэн, ард түмэн нь болон дэлхий нийт тэдний электрон төлөөллийн чанарыг богино хугацаанд дүгнэх боломжтой болжээ. Үүнээс гадна тухайн улсын электрон төлөөллийг хэрхэн зөв удирдаж, ашиглаж байна вэ гэдэг нь хамгийн чухал асуудлуудын нэг хэдийнээ болжээ.

Монгол улсын Засгийн газар нь олон төрлийн ашиг сонирхлыг илтгэсэн, төрөл бүрийн агуулга бүхийн вэб сайтуудыг ажиллуулдаг. Үйл ажиллагаагаа идэвхтэй явуулдаг, шинэлэг мэдээ, сонирхолтой агуулга бүхий вэб сайтуудын хажуугаар байнга шинэчлэгдэн, шинэ мэдээллээр хангаж чаддаггүй вэб сайтууд ч байна. Ерөнхийдөө Монгол улсын Интернет дэх дүр төрхийг эрс сайжруулахын үйл явцыг зарим нэг голлох үүрэг бүхий вэб хуудсуудыг нарийн төлөвлөгөөний дагуу өөрчлөх замаар хийж болно. Эдгээрийн нэг нь Ерөнхий сайдын ажлын албаны дэргэд үйл ажиллагаагаа явуулж буй *Нээлттэй Засаг* (НЗ) вэб хуудас юм ([www.open-government.mn](http://www.open-government.mn)).

Монгол, Англи хэл дээр гардаг НЗ вэб хуудас нь Ерөнхий сайд, Засгийн газрын бүрэлдэхүүний электрон төлөөлөл бөгөөд шинээр батлагдаж буй хууль, хуулийн нэмэлт өөрчлөлтүүд, журмуудыг батлах, хэрэгжүүлэхэд олон нийтийн оролцоог дээшлүүлэх харьцангуй хялбар аргыг хэрэгжүүлэх тал дээр тэргүүлэн ажиллаж байна. Энэ харьцангуй хялбар горим нь шинээр хууль батлах, одоо мөрдөгдөж буй хууль, журмуудад нэмэлт өөрчлөлт хийх явцад дутагдаж буй ил тод байдлыг шийдвэрлэхэд чиглэгдсэн.

### Бэрхшээл

Шинээр батлагдаж буй хууль, хуулийн нэмэлт өөрчлөлтүүдийн талаар мөрдөж буй өнөөгийн тогтолцоо нь доорх байдлаар ажилладаг. Үүнд:

- Санал болгож шинэ хууль, хуулийн нэмэлт өөрчлөлтийн талаар олон нийтэд цаг тухайд нь мэдэгдэж чаддаггүй.
- Хууль, хуулийн нэмэлт өөрчлөлтүүдийн төсөлд олон нийтийн саналыг авах үүднээс мэдээллийн хэрэгслээр тэр бүр мэдээлдэггүй.
- Хуулийг санаачлагчдаас шалтгаалан хуулийн төсөл нь хэд хэдэн шат дамжлаг дамждаг учир эдгээр хууль, журамд олон нийтийн саналыг авах хамгийн доод талын тогтсон хугацааг тодорхойлсон журам байдаггүй.
- Олон нийтийн саналд хариу өгөх журам байхгүй.

Үүний улмаас хэдийгээр олон нийтийн сонирхлыг татаж байсан ч уг хуулийн тухай сонсож, уншиж судлах юмуу саналаа өгөх боломжоор тэр бүр хангаж чаддаггүй учир хууль, хуулийн нэмэлт өөрчлөлт батлагдах шатанд орсон хойно л энэ тухай мэдээлэл олон нийтэд хүрдэг. Ийм тохиолдолд засгийн газар ямар нэгэн зүйл нуухыг оролдож байна гэх юм уу эсвэл ил тод биш байна гэж олон нийтийн зүгээс үздэгийг буруутгах аргагүй юм.

### Санал болгож буй асуудал

ЭЗБШӨЧ Төсөл нь Хууль Зүйн Үндэсний Төв (ХЗҮТ)-тэй хамтран энэ асуудалд холбогдох хууль, Засгийн газар, УИХ-ын тогтоол, журмуудыг судлан, Засгийн газрын бүрэлдэхүүнд өргөн барих саналыг боловсруулан, “100 өдрийн хөтөлбөрийн” хүрээнд батлуулах талаар ажиллах боломжтой юм. ЭЗБШӨЧ Төсөл нь шаардагдах өөрчлөлтүүдийг хийх тал дээр НЗ вэб сайтад үзүүлэх тусалцаагаа үргэлжлүүлнэ. Харгалзаж үзвэл зохих хэд хэдэн асуудлуудыг бид санал болгож байна. Үүнд:

1. ХЗҮТ, ЭЗБШӨЧ Төслийн хууль зүйн/мэргэжлийн дэмжлэг бүхий ажлын хэсэг байгуулж, УИХ-ын Хэвлэл Мэдээллийн Албаны дарга Ч. Сайханбилэгээр удирдуулан, бусад гишүүдийг УИХ, Ерөнхийлөгчийн Тамгын Газар, Хууль Зүй, Дотоод Хэргийн Яамнаас бүрдүүлэх замаар үйл ажиллагааны зорилго, төлөвлөгөө, оролцогч талуудын үүрэг, ажлын хуваарь болон мөрдөгдөж буй журамд нэмэлт өөрчлөлт хийх тал дээр ажиллаж болно.
2. Одоо мөрдөгдөж буй журамд нэмэлт өөрчлөлт оруулах зорилго нь яамдаас санаачилсан хуулийг НЗ вэб хуудас дээр, харин УИХ юмуу Ерөнхийлөгчөөс санаачилсан хуулийг холбогдох вэб сайтууд дээр (НЗ вэб хуудастай холбон) олон нийтийн саналыг авах үүднээс зайлшгүй нийтэлж байх; аливаа хуулийн төслийн анхны болон дараа дараагийн төслийн хувилбарууд дээр олон нийтийн саналыг заавал авах хамгийн доод талын хугацааг тодорхойлох болон олон нийтийн саналд хариу өгөх журмыг тодорхойлох, хэрэгжүүлэхэд оршино.
3. Ажлын хэсгийн эцсийн тайланг Засгийн газрын 2000 оны 178 дугаар Тогтоолд оруулах нэмэлт өөрчлөлтийн төсөл хэлбэрээр 2004 оны 11 дүгээр сарын 8-ны өдрийн дотор Ерөнхий Сайдын Ажлын Албанд хүргүүлнэ. Улмаар үүнийг Засгийн газрын хуралдааны хөтөлбөрт багтаах боломжийг харгалзан үзнэ.
4. Хэдийгээр бусад вэб сайтууд хууль, хуулийн нэмэлт өөрчлөлтүүдийн эцсийн, батлагдсан хувилбарыг нийтэлж болох ч ХЗҮТ өөрийн вэб хуудсанд дахь бүх хуулийг нийтлэх, байнга шинэчлэн тавих өөрийн үндсэн үүргээ биелүүлэх хэрэгтэй.